

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН
2017 ОНЫ 1-Р УРИРАЛД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2017.03.25.

Арвайхээр.

Тус цагдаагийн газрын алба хаагчид нь Цагдаагийн Ерөнхий Газраас 2017 онд дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн Ерөнхий Газрын даргын тушаалаар 2009 онд баталсан "Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт", "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам", холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нэг. Цагдаагийн газрын товч танилцуулга

Тус цагдаагийн газар нь 1939 онд Дотоод явдлын яамны сайдын тушаалаар “Цагдан сэргийлэх анги” нэртэй байгуулагдан хөгжсөөр Хархорин суманд сум дундын цагдаагийн хэлтэс, Хужирт суманд цагдаагийн тасаг, Уянга, Батэлзий суманд цагдаагийн хэсэг төвдөө Эрүүгийн цагдаа, Төлөвлөлт зохион байгуулалт, Хэрэг бүртгэх мөрдөн байцаах, Замын цагдаа, Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Шүүх шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсэг гэсэн зохион байгуулалтын нэгжтэй нийт 180 алба хаагч 5 энгийн ажилтантайгаар аймгийн хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн үүргээ биелүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээн 2016 оны жилийн эцсийн байдлаар 113991 хүн ам, 5208.6 мянган мал тоологдсон бөгөөд Архангай , Булган, Баянхонгор аймагтай хиллэдэг хангайн сумдад малын хулгайн гэмт хэрэг, Арвайхээр, Хархорин зэрэг томоохон сумдад орон байрны хулгайн гэмт хэрэг, баруун чиглэлийн 2 засмал зам аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрдөгөөс хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг зөрчил ихээр үйлдэгдэж, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал хэвийн хэмжээнд бус байна.

Хоёр. 1-р улиралд хэрэгжүүлж буй ажил арга хэмжээ

Энэ хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тогтоол, эрх зүйн бичиг баримт, Хууль зүй дотоод хэргийн сайд, ЦЕГ-ын даргын “Цагдаагийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн” дээр өгсөн үүрэг ажлын чиглэл, дэд дарга нарын өгсөн үүрэг даалгавар, тушаал, шийдвэрийг бие бүрэлдэхүүнд танилцуулж, үр дүнгийн гэрээнд тусгуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. 2017 оны эхний 3 сард иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас гэмт хэргийн шинжтэй 441 гомдол, мэдээллийг хүлээн авч 210 гомдол, мэдээлэлд нь эрүүгийн хэрэг үүсгэн, 205 гомдол, мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал прокурорт хүргүүлж, бүх гомдол

мэдээллийг 100% хуулийн хугацаанд нь шалгаж, гомдол мэдээлэл гаргагчид хариуг нь өгч, одоо үлдэгдэл 26 гомдол, мэдээлэлтэй байна. Нийт хүлээн авсан гомдол, мэдээллийн 183 гомдол мэдээллийг буюу 44 %-ийг нь 5 хоногт 49.3%-ийг 5-19 хоногт шийдвэрлсэн байна. Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагч нар мэдээ, мэдээлэл авч баримтжуулан шалгаж 144 холбогдогчтой, 178435,0 мянган төгрөгний хохиролтой, 103 материалаар 168 хэрэг үйлдлийг илрүүлэн эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулахаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албанд шилжүүлэн ажилласан байна. Илрүүлсэн 168 хэрэг үйлдлээс эзэн холбогдогч нь тогтоогдоогүй үндэслэлээр түдгэлзүүлсэн 13 хэргийг нөхөн илрүүлж ажилласан байна. Гүйцэтгэх ажил зохиолгохоор хэрэг бүртгэх мөрдөн байцаах албанаас 37 даалгавар хүлээн авч хариуг хугацаанд нь өгч, бусад албадаас гэмт хэргийн талаар 41 илтгэх хуудсыг хүлээн авч шалгаж шийдвэрлэж ажиллав. Тус газрын Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсэг 2017 оны 05 дугаар сарын байдлаар иргэд аж ахуйн нэгж, байгууллагаас 41 гомдол, мэдээлэл хүлээн авч 25 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж 14 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, 2 гомдлыг хуулийн хугацаанд нь шалгаж байна. Гүйцэтгэх ажлын шугамаар 17 материалаар 34 холбогдогчтой 49.6 сая төгрөгийн хохиролтой 22 үйлдлийг баримтжуулан эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулахаар холбогдох албанд хүргүүлэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд 23 сая төгрөгийн хохирлыг барагдуулсан. Эдгээр гэмт хэргийн улмаас адуу 34, үхэр 11, хонь 40, ямаа 7 алдагдсан . 2017 оны эхний 5 дугаар сард адуу 22, үхэр 15, хонь 1, ямаа 1-ийг алдуул малаар бүртгэж авч цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах “ASAP” санд шивж оруулан эрэн сурвалжилж ажиллаж байгаа ба мал хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт 70.8%-тай байна. Мөн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, үйлдэгдээд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй болон түдгэлзүүлсэн хэргүүдийг нөхөн илрүүлэх, оргон зайлсан сэжигтэн, яллагдагчийг олж баривчлах, тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Сар шинэ”, “Хулгай 2017-1” “Зах”, “РС-1,2,3”, “School police -1,2”, “Хөрш айл”, “Хөрш айл -2”, “Баг аюулгүй орчин”, “Захиргааны хяналт”, “Хамгаалах бүс”, “Согтуу”, “Нийтийн тээвэр”, “Хурд”, “Хот хоорондын хяналт”, “Согтуу”, “Баг” “Мотоцикл”, “Иргэн таны төлөө” гэх мэт нийт 25 удаагийн хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулсаны үр дүнд гэмт хэргийн гаралт 7.2 хувиар буурч, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт 36,3 хувиар буурсан байна

Тус аймгийн Хархорин суманд 2017 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Хангайн бүсийн аймгуудын мал хулгайлах болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүс нутгийн хамтын ажиллагаа зөвлөгөөнийг зохион байгуулж Архангай, Хөвсгөл, Баянхонгор, Булган, Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газрын удирдлага болон мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн дарга, Өвөрхангай аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дарга, аймгийн хууль эрх зүйн хэлтсийн дарга,

Өвөрхангай аймгийн Хархорин сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Прокурорын газрын дарга, Улсын мөрдөн байцаах газрын Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн дарга, ахлах төлөөлөгч нар оролцож Мал хулгайлах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал хийж гүйцэтгэсэн ажил, цаашид хийж гүйцэтгэх ажлын талаар мэдээлэл хийж, хийж гүйцэтгэх ажлын талаар 8 зүйл бүхий зөвлөмж гарган түүнийхээ дагуу төлөвлөгөө боловсруулан Хангайн бүсийн цагдаагийн газрын дарга нараар батлуулан ажиллаж байна. Цагдаагийн газрын хэмжээнд нийгмийн хэв журам, хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн 5045 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1251 буюу 32.9 хувиар өссөн. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, бусдын амгалан тайван байдал алдагдуулсан 638 хүнийг саатуулж, 235 хүн баривчлан, 4810 хүнийг 218.9 сая төгрөгөөр торгож, 145 хүний авто машин жолоодох эрхийг хасаж ажилласан нь өмнөх оноос торгож, эрх хасагдсан жолооч 14 буюу 10.6 хувиар өсч, баривчлагдсан хүн 164 буюу 3.3 дахин, торгосон хүн 2123 буюу 79 хувиар тус тус өсч, торгуулийн хэмжээ 99 сая төгрөгөөр буюу 83.1 хувиар өсч, саатуулагдсан хүн 127 буюу 24.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Зам тээврийн хөгжлийн яам, Замын цагдаагийн албаны Орон нутгийн хяналтын хэлтэстэй хамтран Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэр Тарнын уулзвараас Нарийнтээл сум хүртэлх 325 км, Тарнын уулзвараас Хархорин сум хүртэлх 77км, Хархорин сумаас Хужирт сум хүртэлх 45 км замуудын эвдрэл, хар цэгүүдийн судалгааг хамтран гаргалаа. 2017 оны эхний 4 сард зам тээврийн ослын 80 дуудлага хүлээн авсан бөгөөд урд оны мөн үетэй харьцуулахад 38-аар буюу 32.2 хувиар, зам тээврийн ослын улмаас нас барсан хүнийг урд оны мөн үетэй харьцуулахад 6-аар буюу 66.6 хувиар тус тус буурсан, хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн хэрэг 16 бүртгэгдсэн бөгөөд 1-ээр буюу 6.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн 1216 жолоочид бэлэн бус хэлбэрээр захиргааны арга хэмжээ ногдуулсан нь урд оны мөн үетэй харьцуулахад 2.2 дахин, торгуулийн хэмжээ 2.3 дахин, шийтгэвэрээр 186 жолоочид торгуулийн арга хэмжээ оногдуулсан нь 30 хувиар, торгож, эрх хассан шийтгэл нь 1.6 хувиар, баривчилсан шийтгэл 31 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна. Тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, хуваарийн дагуу “Эвдрэл гэмтэл-техникийн зөрчил”, “Тээврийн хэрэгслийн гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Тээврийн хэрэгслийн өнгө, үзэмж”, “Ачааны автомашин-ачаа тээвэрлэлт” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг хуваарийн дагуу зохион байгуулан ажилласан нь үр дүнтэй ажил болж, нас баралт буурсан үзүүлэлттэй, зөрчил илрүүлэлт өссөн үзүүлэлттэй байна.

Гурав. Алба хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн талаар зохион байгуулж буй ажил.

ЦЕГ-ын удирдлагаас ирүүлсэн үүрэг ажлын чиглэлийн дагуу “Цагдаагийн албаны тухай

хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг алба, хаагч иргэд олон нийтэд сурталчлах ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж биелэлтийг Олон нийт цагдаагийн хамтын ажиллагааны төвд хүргүүлэв. Шинээр батлагдсан цагдаагийн албаны тухай хуулийг бүлэг бүрээр сургагч багш нар хариуцан алба хаагч нарт сургалт зохион байгуулсан бөгөөд шинээр батлагдан гарсан журмуудыг тухай бүр нийт бүрэлдэхүүнд мэдээлж сургалт зохион байгуулж байна. 2017 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Монгол улсын Их хурлаас баталсан “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн эх бичвэрийг хүлээн авах, цагдаагийн тангараг өргөх ёслолын ажиллагааг Арвайхээр, Хархорин суманд зохион байгуулж, нийт алба хаагч нар хамрагдсан ба иргэд олон нийтэд хэвэл мэдээллийн хэрэгсэл байгууллагын цахим сайтаар дамжуулан сурталчлав. Цагдаагийн газрын даргын тушаалаар томилж байгууллагын “Дотоод журам” боловсруулах ажлын хэсэг томилж бусад байгууллагын туршлага, алба хаагчдын санал зэргийг тусган журмыг шинээр боловсруулж даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн газрын даргын тушаалаар баталсан бөгөөд ун журамд заасны дагуу долоо хоног бүрийн мягмар, пүрэв гаригуудын өглөөний 09 цагаас нийт бүрэлдэхүүний болон тасгийн сургалтыг зохион байгуулж эхлээд байна. Мөн тасгуудаас сургагч багш нарыг сонгон тушаалаар томилж, сургалтын үр дүнг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны зөвлөлийн хурлаар хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгч байхаар шийдвэрлэв. Энэ хугацаанд Хууль сахиулахын их сургуулийн эчнээ дамжаанд 6 алба хаагч Сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулсан мэргэшүүлэх болон давтан сургалтанд 6 алба хаагч, сэтгэл зүйчийн мэргэшүүлэх сургалтанд 1, архивын ажилтнуудын сургалтанд 1, нохойн төлөөлөгчийн сургалтанд 1 алба хаагч тус тус хамрагдсан байна. Сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа, нийт алба хаагч нарт “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэглэх ур чадвар олгох”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/37 дугаар тушаалаар батлагдсан “Аюулын зэргийн үнэлгээ хийх журам”, 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/25 дугаар тушаалаар батлагдсан “Гэр бүлийн хүчирхийллийн талаархи статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам”, 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/38 дугаар тушаалаар батлагдсан “Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам”, Улсын ерөнхий прокурор, Хууль,зүй дотоод хэргийн сайдын хамтарсан 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/22, А/31 дугаар тушаалаар батлагдсан “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам” зэрэг сэдвээр 8 сургалтын материал бэлтгэж, албаны сургалтыг 4, зайны сургалтыг 12 удаа 120 алба хаагчийг хамруулан зохион байгуулсны үр дүнд алба хаагчдын мэдлэг, хууль хэрэглэх ур чадвар дээшилсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдсантай холбогдуулан Хууль зүй дотоод хэргийн сайдын тушаалаар батлагдсан цагдаагийн байгууллагатай холбоотой 9 журмыг цагдаагийн алба хаагчдад хэрэглэх ур чадвар олгох сургалтыг 12 удаа зохион байгуулж, хөгжөөнт

“АХА” тэмцээнээр мэдлэгийг шалгалаа. Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газраас санаачлан “Дэлхийн зөн Өвөрхангай” орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Би гэр бүлдээ үүнийг хүсдэг” аяныг 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Арвайхээр суманд зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн “Өсвөрийн цагдаа”, “Өсвөрийн аврагч”, “Өсвөрийн сурвалжлагч”, “Номын анд”, “Ангийн дарга нарын нэгдэл”, “Нэгдмэл ертөнц” зэрэг хүүхдийн өөрөө удирдах 13 байгууллагын 400 гаруй сурагчид оролцлоо. Олон улсын гэр бүлийн өдрийг угтаж Дэлхийн зөн Өвөрхангай орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Бусдыг өөрийн адил хайрлацгаая” уриан дор “Гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчье” challenge-ийг 2017 оны 05 дугаар сарын 09-ний өдөр эхлүүлж, Challehge-д аймгийн Онцгой байдлын газар, Засаг даргын тамгын газар, аймгийн Боловсрол соёл, урлагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Шүүхийн шинжилгээний алба, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Боловсролын өмнөх байгууллага, Ерөнхий боловсролын сургуулиуд зэрэг 42 гаруй байгууллагын 2500 гаруй алба хаагчид нэгдлээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг төрийн албан хаагчдад сурталчилах зорилгоор “Амар тайван гэр бүл” дэвжээ тэмцээнийг 2017 оны 05 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулав. Тэмцээнд 22 байгууллагын 44 төрийн албан хаагч оролцож, 12 байгууллагын алба хаагч нар оролцсон “Элэг нэг” баг тэргүүн байр, “Инээмсэглэл” баг 2 дугаар байр тус тус эзэлж, аймгийн Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх Ажлыг Зохицуулах Зөвлөлөөс өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав. ЦЕГ болон түүний албад, бусад байгууллагуудад 2026 албан бичиг, тоотыг хүргүүлж, бусад газраас Цагдаагийн газарт ирүүлсэн 1325 албан бичгийг хүлээн авч биелэлтийг тооцон, 778 хариуг хугацаанд нь хүргүүлж 89 албан бичгийн хугацаа дуусаагүй байна. ЦЕГ-ын даргын зөвлөлийн шийдвэрийг тухай бүр бие бүрэлдэхүүнд танилцуулж, цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу 10 удаа хийж, цагдаагийн газрын даргын А тушаал 54, Б тушаал 33 гаргаж холбогдох асуудлыг шийдвэрлэв. Газрын даргын тушаал боловсруулах батлуулах үйл ажиллагааг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хяналтын хувийн хэрэг нээж бүрдүүлэлтийг хийн ажиллаж байгаа бөгөөд энэ оны эхний 5 сард албанаас дутагдлаар халагдсан нэг алба хаагч аймгийн Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргаж маргаан үүсгэсэн боловч газрын даргын тушаал үндэслэлтэй болох нь тогтоогдов.

Хууль зүй дотоод хэргийн яамнаас зохион байгуулж буй “Захиргааны ерөнхий хууль”-ийн сургалтанд тус газрын ахлах албан тушаалтнуудаас дээш албан тушаалтай алба хаагч нар оролцож байна.

Дөрөв. Тулгамдаж буй асуудлын талаар

1. Цагдаагийн газрын шинэ барилгын ажлыг эхлүүлэх / 2011 онд шинээр баригдах барилгын зураг төсвийг 21 сая төгрөгөөр хийлгэж, газрын асуудлыг шийдвэрлэсэн боловч барилгын төсөв батлагдаагүй/

2. Хужирт сум дахь цагдаагийн тасгийн кобан байрны барилга, унааны асуудлыг шийдвэрлүүлэх /Тус тасаг нь 5 орон тоотойгоор Засаг даргын тамгын газрын 2 өрөөнд үйл ажиллагаа явуулж байгаа ба алба хаагчид нь өөрийн орон байргүйгээс сургуулийн дотуур байрны өрөөнд амьдарч, сургуулийн захиргаа эцэг эхүүдээс гомдол гарч алба хаагчдын амьдрах нөхцөл хүндэрч байна/.

3. Бүрд сумын нутаг Элсэн тасархайд баригдаад ашиглалтанд ороогүй байгаа аймаг дундын “Замын цагдаагийн хяналтын байр”-ны үйл ажиллагааг эхлүүлэх

4. ОХУ-д үйлдвэрлэгдсэн туулах чадвар сайтай, сэлбэг хямд УАЗ -31512 , Пургон автомашинаар хангуулах /2011 оноос хойш энэ төрлийн автомашинаар хангагдаагүй хуучин ашиглаж буй автомашинуудын эдэлгээний хугацаа дуусч үүрэг гүйцэтгэх чадвар муудаж байна/.

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН: ТЗБ-ЫН ТАСГИЙН ДАРГА, ЦАГДААГИЙН
ДЭД ХУРАНДАА Д. ЭРДЭНЭБАТ

ХЯНАСАН: ДАРГА, ЦАГДААГИЙН ДЭД
ХУРАНДАА Я. ГАНБАТ